

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.02.25-03.01

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ-ын хөрөнгийн зах зээлийн Dow Jones индекс буурч, харин S&P 500 болоод Nasdaq индексүүд өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг түүхий эд боловсруулагч компаниудын хувьцааны ханш унасан бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагджээ.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудалд ахиц гарч, хөрөнгийн зах зээлийн индексүүд өсжээ. АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп 2019 оны 3-р сарын 1-нд БНХАУ-ын импортын бараа бүтээгдэхүүнд ногдуулахаар шийдвэрлэж байсан гаалийн татварын арга хэмжээг хойшлуулахаар болжээ. АНУ оюуны өмчийн эрхийн хамгаалалт, технологи дамжуулалт, валютын ханшийн манипуляц, АНУ-аас БНХАУ руу импортлох хөдөө аж ахуй бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх зэрэг асуудалд ахиц гарч байгааг онцоллоо.

12 сард АНУ-ын орон сууцжилтын түвшин эрс буурч, сүүлийн 2 жилийн хамгийн доод түвшинд хүрлээ. Орон сууцны үнэ таамагласан хэмжээнээс багаар өссөн бол АНУ-ын хэрэглээний түвшин огцом буурчээ. Мөн аж үйлдвэрлэлийн салбарын үзүүлэлтүүд сул хэвээр байгаа аж.

Урт хугацаат Засгийн газрын үнэт цаасны өгөөж өсөж, 2-р сарын хамгийн дээд түвшинд хүрчээ.

**Европ:** Энэтхэг, Пакистаны зөрчилдөөн, АНУ, Хойд Солонгосын төрийн тэргүүнүүдийн дээд хэмжээний уулзалт саналын зөрөлдөөнтэй өндөрлөсөн зэргээс үл хамаарч Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн STOXX Europe 600 индекс өсөлттэй хаагдлаа.

"Brexit" хэлэлцээрийн тодорхойгүй байдлаас шалтгаалан Их Британийн хөрөнгийн зах зээлийн индекс 1 хувиар буурчээ. Тус улсын Ерөнхий сайд Тереза Мэй "Brexit" хэлэлцээрийн төслөөр Парламентын санал хураалтыг 3-р сарын 12 хүртэл хойшлуулахаа мэдэгдээд байна. Хэрэв уг төсөл Парламентын дэмжлэг авахгүй бол Европын Холбооноос ямар нэгэн хэлэлцээргүй гарах асуудлаар олон нийтээс санал хурааж магадгүй байна. Ингэснээр, Их Британийн фунт ам.долларын эсрэг чангарч, хөрөнгийн зах зээлийн индекст сөргөөр нөлөөлсөн байна.

"IHS Markit" байгууллагын мэдээлснээр 2-р сард Европын бүсийн аж үйлдвэрийн худалдан авагч менежерүүдийн индекс 7 долоо хоног дараалан унаж, 50 нэгж хүрэхгүй болжээ.

**Япон:** Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 0.8 хувиар өсжээ.

Байгалийн гамшгийн дараа 2018 оны 4-р улиралд Япон улсын эдийн засаг сайжирч, тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргаан Япон улсын экспортын хэмжээнд бага зэргийн дарамт үүсгэсэн ч, тус улсын дотоодын хэрэглээ нэмэгджээ. Олон улсын валютын сангийн урьдчилсан таамгаар 2019 онд Япон улсын эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй байгаа ажээ.

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,081.43	-1.19% ▼
Dow Jones	АНУ	26,026.32	-0.02% ▼
S&P 500	АНУ	2,803.69	0.39% ▲
Nasdaq	АНУ	7,595.35	0.90% ▲
S&P/TSX	Канад	16,068.25	0.34% ▲
FTSE 100	Их Британи	7,106.73	-1.00% ▼
S&P/ASX 200	Австрали	6,192.70	0.41% ▲
Nikkei 225	Япон	21,602.69	0.83% ▲
Hang Seng	Хонг Конг	28,812.17	-0.01% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.84
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.44
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.80
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.52
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.61
DBM' 2023	USD	7.250%	103.25
TDBM' 2020	USD	9.375%	104.51

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.482	-0.00 ▼
Libor 3M	2.598	-0.05 ▼
Libor 6M	2.682	-0.02 ▼
Libor 1YR	2.879	-0.01 ▼
US 2YR Bond	2.555	0.05 ▲
US 3YR Bond	2.538	0.07 ▲
US 5YR Bond	2.558	0.08 ▲
US 10YR Bond	2.755	0.09 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2019.03.01	Өөрчлөлт
USD	2,635.34	0.00% ▲
CNY	393.28	0.30% ▲
EUR	2,997.57	0.28% ▲
RUB	40.06	-0.45% ▼
KRW	2.34	-0.43% ▼
JPY	23.57	-0.97% ▼
CAD	2,006.81	0.67% ▲

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,293.89	-2.75% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	15.23	-4.51% ▼
Зэс	USD/lb.	294.00	-0.24% ▼
Нүүрс	USD/MT	96.50	3.26% ▲
WTI газрын тос	USD/bbl.	56.02	-1.89% ▼
Brent газрын тос	USD/bbl.	65.34	-2.32% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.85	2.89% ▲

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. I	7.30%
Бодлогын хүү	2019. I	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. I	11.10%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. I	12.10%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. I	4.90%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. I	16.80%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. I	10.60%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 42 компанийн 751.6 сая төгрөгийн 2,026,106 ширхэг хувьцаа арилжигдав.


“Эрчим баян өлгий” /BOE/ компанийн хувьцаа 26.15%-аар буюу хамгийн ихээр өсч 820.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Булган гурил тэжээл” /GTJ/ компанийн хувьцаа 14.58%-аар буурч 1,025.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч бзах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 9,670 ширхэг үнэт цаас 998.5 сая төгрөгөөр арилжаалагджээ.


3-р сарын 1-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,475.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,081.43 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.19%-аар буурсан байна.

## MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



\*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,750.1
Зах зээлийн үнэлгээ	2,475,511.8

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,081.43	-1.19% ▼
MSE I индекс	9,730.73	-1.98% ▼
MSE II индекс	8,441.78	-0.56% ▼

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Мандал даатгал	34,763	173,825,156
Ард даатгал	209,716	147,407,192
АПУ	221,221	139,621,307
Говь	185,320	60,149,360
ЛэндМН	875,808	59,802,297

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Эрчим баян өлгий	820.00	26.15% ▲
Монгол савхи	575.00	14.77% ▲
Хөх ган	70.00	14.57% ▲
Баянтээг	27,400.00	14.36% ▲
Могойн гол	7,900.00	12.86% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Булган гурил тэжээл	1,025.00	-14.58% ▼
Монгол нэхмэл	1,801.00	-14.24% ▼
Шивээ овоо	2,042.00	-10.44% ▼
Би Ди Сек	860.18	-8.50% ▼
Жинст Увс	1,660.00	-7.78% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	3,339,059,866
Тэнгэр капитал	724,610,400
Ард капитал групп	376,768,751
Ард секьюритиз	281,225,378
Би Ди Сек	134,958,277

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	627.43	667,699
Таван толгой	7,105.00	374,186
МИК	12,800.00	265,079
Говь	318.36	248,357
Сүү	210.00	72,240

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.15
2	LEND	ЛендМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.05.01-ний дотор
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	N/A	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрийд ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	N/A	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	N/A	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	N/A	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	N/A	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	N/A	2019.10.01-с
10	BUK	УБ-БУК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	N/A	2019.05.01-с
11	TAN	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	N/A	2019.05.01-ний дотор
12	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	N/A	2019.05.01-с
13	HRD	Хүрд ХК	N/A	74.4	N/A	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
14	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	N/A	2019.05.01-2019.05.31
15	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
16	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
17	APU	АПУ ХК	N/A	48,952.4	N/A	46.0	2019.02.19	N/A	2019.12.31-ний дотор
18	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
19	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	N/A	2019.10.01
20	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-01/08/19-A0285-13.745	98	9,851,940	100,430	100,630	104	13.745%
2	ZGEB-BD-04/07/19-A0266-14.82	92	9,268,080	100,660	100,820	104	14.820%
3	ZGEB-BD-06/06/19-A0254-15.49	96	9,666,720	100,630	100,760	104	15.490%
4	ZGEB-BD-06/06/19-A0254-15.49	30	3,024,000	100,800	100,800	104	15.490%
5	ZGEB-BD-11/04/19-A0230-18	500	50,295,000	100,590	100,590	104	18.000%
6	ZGEB-BD-15/08/120-A0295-14.5	3,501	361,790,000	100,000	103,340	156	14.500%
7	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	5	518,250	103,650	103,650	156	15.140%
8	ZGEB-BD-24/10/19-A0348-13.955	146	14,743,080	100,830	101,130	104	13.955%
9	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	3,608	378,370,960	104,600	105,140	156	16.993%
10	ZGEB-BD-26/09/19-A0326-13.955	122	12,307,360	100,750	101,010	104	13.955%
11	ZGEB-BD-26/09/19-A0326-13.955	1,350	136,390,500	101,030	101,030	104	13.955%
12	ZGEB-BD-29/08/19-A0305-14	122	12,297,600	100,680	100,920	104	14.000%

## ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
1	HRM	Гермес центр ХК	2019.02.18	2019.03.07	15:00
2	SVR	Эрдэнэт суврага ХК	2019.02.08	2019.03.11	11:00
3	BLG	Завхан баялаг ХК	2019.02.27	2019.03.18	10:00
4	LEND	ЛэндМН ББСБ ХК	2019.02.22	2019.03.23	12:00
5	DLH	Эм Эн Ди ХК	2019.03.11	2019.03.28	15:00
6	EAZ	Эрдэнэт авто зам ХК	2019.03.14	2019.03.29	10:00
7	BTG	Баянтээг ХК	2019.03.04	2019.04.01	10:00
8	GTL	Гутал ХК	2019.03.10	2019.04.01	11:00
9	АНН	Хоринхоёрдугаар бааз ХК	2019.03.11	2019.04.01	13:00
10	MNB	Мон Наб ХК	2019.03.14	2019.04.04	14:00
11	MIB	Монинжбар ХК	2019.02.05	2019.04.05	14:30
12	HRD	Хүрд ХК	2019.03.04	2019.04.05	16:00
13	VIK	Баян-Алдар ХК	2019.03.04	2019.04.08	10:00
14	HUZ	Хөвсгөл усан зам ХК	2019.02.28	2019.04.08	09:00
15	MIE	Материалимпекс ХК	2019.03.11	2019.04.09	10:30
16	AZH	Алтайн зам ХК	2019.03.19	2019.04.10	16:00
17	BHL	Бөөний худалдаа ХК	2019.03.14	2019.04.10	16:00
18	ALI	Стандарт ноос ХК	2019.03.18	2019.04.10	15:00
19	TEX	Техникимпорт ХК	2019.03.11	2019.04.11	15:00
20	UBH	Улаанбаатар хивс ХК	2019.03.18	2019.04.11	11:00
21	TLP	Тулпар ХК	2019.03.11	2019.04.15	15:00
22	BRC	Барилга корпораци ХК	2019.03.18	2019.04.18	10:00
23	BDS	Би Ди Сек ХК	2019.03.22	2019.04.23	10:00
24	AIC	Ард даатгал ХК	2019.03.15	2019.04.27	09:00



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**“ЛэндМН ББСБ” ХК-ийн үнэт цаасыг бүртгэлийн ангилал ахиуллаа**

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйлийн 20.2, 20.3.6 дахь заалтууд болон “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 1/153 тоот албан бичгээр ирүүлсэн ангилал ахиулах тухай хүсэлт зэргийг тус тус үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаалаар “ЛэндМН ББСБ” ХК-ийн үнэт цаасыг “II” ангиллаас ахиулан “I” ангилалд бүртгэлээ.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

**“Ард кредит ББСБ” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга нийлүүлэлтээсээ давж хаагдлаа**

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2019 оны хоёр дахь IPO болох “Ард Кредит ББСБ” ХК нь нийт хувьцааны 25% буюу 70,000,000 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс 3 дугаар сарын 1-ний өдрийн 17:00 цаг хүртэл авч дууслаа. “Ард Кредит ББСБ” ХК-ийн олон нийтэд санал болгосон хувьцааны анхдагч зах зээлийн захиалгад нийт 1,763 хувь хүн, аж ахуйн нэгж оролцож нийт 7,318,438,999 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирүүлсэн нь олон нийтэд санал болгосон татан төвлөрүүлэх доод дүнгээс 3 дахин давсан үзүүлэлт боллоо.

“Ард Кредит ББСБ” ХК нь шинээр олон нийтэд санал болгож байгаа 35 сая ширхэг үнэт цаасыг МХБ-ийн “Анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын Захиалга бүртгэлийн аргыг ашиглан 70-85 төгрөгийн хооронд санал болгосон билээ. Захиалгын дийлэнх нь 85 төгрөгөөр ирсэн хэдий ч үнэт цаас гаргагч “Ард Кредит ББСБ” ХК болон андеррайтерийн компани болох “Ард Капитал ҮЦК” ХХК-ийн зүгээс МХБ-ийн журам, хөрөнгө оруулагчдад өгөх өгөөжийг харгалзан үзэж нэгж хувьцааны нийлүүлэх үнийг нийт ирүүлсэн захиалгын тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханш буюу 81 төгрөгөөр тогтоохоор шийдвэрлэлээ. Тогтоосон ханшнаас доогуур захиалга өгсөн оролцогчдын захиалга биелэх боломжгүй бөгөөд 81 төгрөгөөс дээш өгсөн захиалгыг журмын дагуу 43.73 хувиар хувь тэнцүүлэн тооцож хуваарилалт хийнэ.

СЗХ-оос “Ард Кредит ББСБ” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх шийдвэрийг гаргасан үед хөрөнгө оруулагчид тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн үлдэгдэл мөнгөн хөрөнгийг буцаан авах эрх үүснэ.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

**“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд**

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй, Монгол Улсад хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX: ERD | MSE: ERDN) нь Торонтогийн хөрөнгийн биржид 11,014,544 ширхэг үнэт цаасыг нэмэлтээр бүртгүүлж, нэг бүрийг нь 0.23 канад доллароор хаалттай хүрээнд санал болгон худалдаж, нийт 2,533,345 канад долларын хөрөнгийг татан төвлөрүүлсэн байна.

Тус компани нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг Хөндий Алтны Төслийн Урьдчилсан Техник Эдийн Засгийн Үндэслэлийг боловсруулах, ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах, Монгол Улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас олгож эхэлсэн тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцох, компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

**Дархан нэхий ХК: Экспорт хумигдсан нь борлуулалт буурахад нөлөөлсөн**

Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Дархан нэхий” ХК 2018 онд 12 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон нь 2017 оныхоос 37 хувиар буурсан талаар санхүүгийн тайландаа дурджээ. Тайлангаас харвал тус компанийн ерөнхий ба удирдлагын зардал 2018 онд 62 хувиар өсөж, хоёр тэрбум гаруй төгрөг болсон байна. Гадаад валютын ханшийн зөрүүнээс 2017 онд 13.4 сая төгрөгийн алдагдал хүлээж байсан бол 2018 онд 8.9 сая төгрөгийн олзтой ажиллажээ. “Борлуулалтын орлого буурсан нь гадаад зах зээлийн эрэлт буурсантай холбоотой” гэж “Дархан нэхий” ХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Батсайхан онцоллоо. Өмнө нь борлуулалтынхаа 50-60 хувийг экспортоос олдог байсан бол 2018 онд 10-20 хувь болтлоо буурсан байна.

“Дархан нэхий” ХК 2018 оныг өөдрөгөөр харж, үйлдвэрлэлээ 20-30 хувиар нэмэгдүүлж, экспортын зах зээлээ тэлэхээр зорьж байсан аж. “Хүү багатай санхүүжилт дотоодоос татахад хүндрэлтэй байгаа” гэдгийг тус компани өмнө нь мөн мэдээлж байсан юм. “Дархан нэхий” ХК-ийн зах зээлийн үнэлгээ 18.2 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Нийт нэг сая нэг мянга гаруй хувьцаа арилжаалж байгаагаас нэгжийнх нь ханш 16,500 төгрөг байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд 23 орчим хувиар буурчээ. Тус компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа ирэх дөрөвдүгээр сард хийхээр товлоосон байна. Мөн энэ жил ногдол ашиг тараахгүй байж магадгүй гэж “Дархан нэхий” ХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Батсайхан онцоллоо.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

**2018 онд ХБНГУ, БНТУ, АНУ-д франчайз дэлгүүрээ нээгээд байгаа “Говь” ХК-ийн борлуулалт 40 хувиар өсжээ**

“Говь” компани 2018 онд нэгж хувьцаанд 22.8 орчим төгрөгийн ашигтай ажилласан байна. Өөрөөр хэлбэл, цэвэр ашгийн хэмжээ нь тайлант хугацаанд 17.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар өсжээ.

Ингэснээр тус компани нийт цэвэр ашгийнхаа 30 хувийг буюу 5.3 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараах шийдвэр гаргаад байна. “Говь” компанийн нийт хувьцааны 84.2 хувийг гурван том хувьцаа эзэмшигч, үлдсэн 15.8 хувийг 16.6 мянган жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байгаа юм. Ийнхүү эдгээр хөрөнгө оруулагчид нэгж хувьцаандаа 6.8 төгрөгийн ногдол ашиг хүртэхээр болж байна.

2018 онд “Шилдэг хувьцаат компани”-аар шалгарсан “Говь” компанийн борлуулалтын орлого 2018 онд 40 орчим хувиар өсөж, 173.4 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнд дотоод болон гадаад борлуулалт нэмэгдэж байгаа нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, 2018 онд “Говь” компанийн шинэ салбар “Галлериа Улаанбаатар” төвд нээгдсэн юм. Энэхүү салбар нь дэлхийн хамгийн том ноолуурын дэлгүүр болсон бөгөөд гадаад, дотоодын худалдан авагчдыг маш богино хугацаанд татаж байгааг тус салбарын захирал мэдээлж байв.

Ноолуурын түүхий эд бэлтгэхээс эхлээд бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх бүх шат дамжлага дотооддоо боловсруулдаг “Говь” компани дэлхийн “Топ 5” ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн тоонд багтдаг. Энэ ч утгаараа олон улсад салбар дэлгүүрийнхээ жил бүр нэмж байна. Тухайлбал, 2018 онд ХБНГУ-ын Дюссельдорф, АНУ-ын Сан Франциско, БНТУ-ын Истамбул хотод франчайз дэлгүүрүүдээ нээсэн юм. “Говь” ХК 2018 оны 12 дугаар сард нэгж хувьцаагаа 100 хуваасан байна. Үүнээс хойш тус компанийн хувьцааны арилжаа идэвхжээд байгаа юм. Сүүлийн байдлаар буюу хоёрдугаар сарын эцсийн байдлаар “Говь” ХК-ийн хувьцааны ханш 324 төгрөг байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Монголбанканд тушаасан алтны хэмжээ II сард 81 хувиар буурчээ

Монголбанк 2019 оны хоёрдугаар сард 84.1 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 438.6 кг алт худалдан авч байснаас 81 хувиар буурсан дүн боллоо. Мөн энэ хугацаанд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 9.5 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 2.3 кг алт худалдаж авчээ.

Алт тушаалт буурсан нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хөнгөлөлттэй буюу 2.5 хувьтай байх хугацаа дууссантай холбоотой гэж Төв банк үзэж байна. Хуулийн хугацаа дууссанаар 2019 оны нэгдүгээр сарын нэгний өдрөөс эхлэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр таван хувь, алтны зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч 0-5 хувийг нэмж, нийт 5-10 хувиар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулж авч байгаа юм. Хоёрдугаар сард дэлхийн зах зээлд алтны ханш өндөр байсантай холбоотой ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 10 хувь байсан тухай Төв банк мэдээллээ. Тухайлбал, алтны зах зээлийн үнэ хоёрдугаар сард 1,300 ам.доллаароос дээш байлаа.

Алт олборлогчдын зарим төлөөлөл алтны татварын хөнгөлөлтийг сунгах эсэхтэй холбоотой хүлээлтийн байдалд шилжсэн тухай мэдээлсэн юм. Харин Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хөнгөлөлтийн хугацааг сунгах заалт бүхий хуулийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Мөн хуулийн төслийг батлуулахад анхаарч ажиллана гэж мэдэгдэж байсан юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Aspire Mining” Овоотын ордын олборлолтыг 2020 онд эхлэхээр төлөвлөж байна

“Aspire Mining” компани Овоотын коксжих нүүрсний ордын олборлолтыг 2020 онд эхлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдлээ. Тус компани нүүрсээ нийлүүлэх боломжит зах зээл нь БНХАУ-ын Хэбэй муж гэж үзэж байна.

Зах зээлийн судалгаагаа “Fenwei Energy”, “Wood Mackenzie” нартай хамтран хийж байгаа аж. “Fenwei Energy”-ийн тооцоолсноор БНХАУ-д “fat coking coal” буюу ган үйлдвэрлэхэд ашигладаг коксжих нүүрсний нийлүүлэлтийн хомсдол 2025 он хүртэлх хугацаанд жил тутамд 16-22 сая болох юм. Энэ орон зайд яг ийм төрлийн нүүрсний нөөцтэй Овоотын коксжих нүүрсний ордын нийлүүлэлт чухал нөлөөтэй гэж “Fenwei Energy” компани дүгнэсэн байна. Тиймээс Овоотын коксжих нүүрс урт хугацаандаа тонн тутамдаа 176-191 ам.долларын үнэ хүрч, Хэбэй мужийн хэрэглэгчдэд хүрэх боломжтой гэж таамаглажээ.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор улс орнууд нүүрсний хэрэглээгээ хязгаарлаж, “Glencore” тэргүүтэй компаниуд олборлолтоо нэмэхгүй байх шийдвэр гаргаад байна. Үүнийг үл харгалзан “Ирээдүйд аж үйлдвэрийн хөгжилд хамгийн их ашиглагдах гангийн үйлдвэрлэлийн гол түүхий эд коксжих нүүрс болох юм. Тиймээс “Коксжих нүүрсний эрэлт тогтвортой байна” гэж харж байгаагаа “Aspire Mining”-ийн Гүйцэтгэх захирал Дэвид Полл “Bloomberg”-т өгсөн тусгай ярилцлагынхаа үеэр онцоллоо.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### Нэг тэрбум ам.долларын санхүүжилттэй уул уурхайн төслүүд

Монгол улсад хэрэгжиж буй 1 тэрбум ам.долларын санхүүжилттэй 3 төсөл байгаа аж.

Үүний нэг нь 1 тэрбум ам.долларын санхүүжилттэй, жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр юм. Дорноговь аймгийн Алтанширээ суманд үйлдвэр байгуулах ажил эхэлсэн бөгөөд дэд бүтцийн ажлуудыг хийж байгаад түр завсарлаад 3-р сараас эргэн сэргээхээр болсон байна. Тус үйлдвэрийг 2022 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй байна. Төслийн менежментийг “Engineers India” компани хийх юм. Харин “Газрын тосны үйлдвэр ашиглалтад орсны дараа түүхий эдийн хангамж тасалдах эрсдэл байгаа” гэдгийг Монголын геофизикийн холбооны Гүйцэтгэх захирал Д.Цэдэнбалжир анхааруулсан. Өмнө нь газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахаар олон удаа оролдож байжээ. “10 гаруй жилийн дотор 17 компанид тусгай зөвшөөрөл олгож, хэдэн газар шав тавьсан ч үйлдвэр босоогүй. Тэгвэл энэ удаад Алтанширээ эцсийн зогсоол мөн үү гэдгийг шийдэх хүн нь дараагийн Ерөнхий сайд ч байж магадгүй” гэж “Asia Mining” сэтгүүлд бичжээ.

Засгийн газар, Оюутолгойн хөрөнгө оруулагчид удаан зөвшилцсөний эцэст төслийг эрчим хүчээр хангах 300 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станцыг Тавантолгойд түшиглэн байгуулахаар шийдвэрлэсэн. Төслийг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтээ хараахан олоогүй байгаа юм. Монголын талыг төлөөлж төсөлд оролцож байгаа “Тавантолгойн цахилгаан станц” компанийн ТЭЗҮ-д тусгаснаар санхүүжилтэд 1 тэрбум ам.доллар шаардлагатай юм байна. Гэхдээ олон улсад уур амьсгалын өөрчлөлтөөс болж нүүрсний цахилгаан станцын төслүүдэд санхүүжилт олгох нь багасаж байгаа нь гол эрсдэлүүдийн нэг гэжээ.

Цагаансуваргын ордын нийт бүтээн байгуулалтад 1.89 сая ам.долларын санхүүжилт шаардлагатай гэж “МАК” ХХК мэдээлсэн. Бүтээн байгуулалтад 377 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийгээд байна. Төслийн бүтээн байгуулалт 47 хувьтай байгаа бөгөөд стратегийн орд учраас төр 34 хувийг нь эзэмших юм. Гэхдээ “Цагаан суваргын ордыг төрийн мэдэлд буцаан авна” гэж Ерөнхий сайд У.Хүрэлсүх мэдэгдсэн нь нэлээд анхаарал татсан үйл явдал болсон.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.